



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/35

Сүхбаатар сум

### Тусгай зөвшөөрөл хүчингүй бслгох тухай


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, Захиргааны эрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 97 тоот тогтоолоор баталсан "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1.5, "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгоход санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг"-ийн 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг "Бүрэн дэлгэр өндөр" ХХК-ий "Оч" хүнсний дэлгүүр "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.8, 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтуудыг зөрчсөн, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгаагүй 1 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан тул "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл"-ийг цуцалсугай.

2. Тусгай зөвшөөрөл цуцлагдсан аж ахуйн нэгжид хоёр жилийн дотор дахин зөвшөөрөл олгохгүй байхыг "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих" ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Б.Мөнхжаргал/-д даалгасугай.

3. Тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа А.Энхбат, Мэргэжлийн хяналтын газрын дарга Ж.Отгонхүү нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ